

НОМЫН ЕРТӨНЦ  
ШҮҮМЖ

**«ХЯТАДЫН СОЦИАЛИСТ  
БАЙГУУЛАЛТ» НОМОНД  
ХЯТАДЫН ОНЦЛОГТОЙ  
СОЦИАЛИСТ БАЙГУУЛЛЫН  
ТУХАЙ ТУСГАСАН НЬ**

(Шанхай, 1986)

Ц. ГЭРЭЛ

Уг номыг ХКН-ын ТХ-ны «Их дээд сургуулиудын үзэл суртал, ёс суртахууны болон улс төрийн эдийн засгийн ухааны хичээлийн сургалтыг шинэчлэх тухай» тогтоолыг үндэслэн Шанхай, Гуаньси, Шаньдун, Ляонин зэрэг муж, хотуудын 14 их, дээд сургуулийн багш нар хамтран зохиожээ. 15 бүлэг бүхий энэхүү номонд Хятад улсын социалист бүтээн байгуулалтын явцыг түүхчлэн дурьдсаны зэрэгцээ Хятад дахь социализм, нийгмийн амьдралын хүрээн дэх зарим нэгэн зүй тогтолт асуудал, ХКН-ын ТХ-ны 1978 оны II бүгд хурлаас дэвшүүлсэн шинэтгэл, «нээлттэй хаалга»-ын чиг шугамыг тайлбарласан байна. Түүнчлэн хятадын онцлогтой социализм, эдийн засгийн гол зангилаа асуудал, соёл, үзэл суртал, улс төрийн бүтээн байгуулалтын үндсэн зорилтыг тодорхойлохыг зорьжээ.

Зохиогч юуны өмнө Хятад улсын социалист бүтээн байгуулалтын 30 гаруй жилийн ололт, дутагдал хийгээд, өнөөгийн зорилтын тухай өгүүлээд, тэдгээртээ тус бүрд нь товчхон үнэлэлт дүгнэлт өгч, хятадын онцлогтой социализм байгуулах зайлшгүй шаардлага гарч ирсэн тухай дурьджээ.

Хятадын онцлогтой социалист байгуулалтын урьдчилсан нөхцөл, үндэс суурь нь «улс орныхоо дотоод нөхцөл байдлыг зөв зүйтэй ойлгоход оршино» (69-р тал) гэж зохиогч үзээд Хятадын дотоод нөхцөл байдлыг нийгмийн, байгалийн гэсэн 2 хүчин зүйлээр тайлбарлан бичжээ.

**Нийгмийн хүчин зүйлсэд** улс орны нийгмийн байгуулал, эдийн засаг, боловсрол, шинжлэх ухаан, соёлын хөгжилтийг хамруулж хятадын хувьд тэр нь ямар хэмжээнд байгааг тус тусад нь задлан авч үзсэн байна. Нийгмийн байгууллын талаар бичсэн хэсэгт Хятад-үйлдвэрлэлийн хэрэгслийг нийтээр өмчилсөн ардын ардчилсан диктатурт социалист улс болохыг тодорхойлжээ. Хэдийгээр «тэргүүний нийгмийн байгуулал (социалист байгуулал—Д. Г.) коммунист намын удирдлага нь өндөр соёл, ардчилалтай хүчирхэг гүрэн болох хэтийн төлөв нээж өгсөн боловч өнөө үед тус улс нь социализмын эхний шатанд оршиж, хөгжиж буй социалист орны хөгжлийн түвшинд байгааг» (70-р тал) зохиогч улмаар дурьдаад үүнийгээ үйлдвэрлэлийн харилцаа, үйлдвэрлэх хүчин, суурь давхаргын харилцаа ерөнхийдөө тохирч байгаа боловч маш боловсронгуй бус байгаа нь эцэстээ улс орны үйлдвэрлэх хүчний хөгжилд нөлөөлснөөр тайлбарлажээ. Чухам ийм учраас социализмын материаллаг болон оюуны соёлын байгуулалтын шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэлийн харилцаанаас давхрага хүртэл өөрчлөлт хийх зорилт цаашид тулгарч байгаа тухай тэмдэглэжээ. Эдийн засгийн хөгжлийн хувьд, хувьсгалын өмнөхтэй харьцуулбал, тус оронд социализмын үндэс суурь тавьсан тухай дурьдахын хамт материал-техникийн бааз, хөдөө аж ахуй нэлээд хоц-

рогдсон хэвээр, цахилгаан эрчим хүчний эх булаг, харилцаа холбоо, мэдээлэл, түүхий эдийн асуудал зохих хэмжээгээр шийдвэрлэгдээгүй байгааг тэмдэглэжээ. Үүнтэй уялдаад эдийн засгийн үр ашиг, доогуур, үйлдвэрлэлийн технологи хоцрогдсон, аж ахуй удирдах мэдлэг, чадварын түвшин дорой зэрэг шийдвэрлэвэл зохих асуудлууд оршсоор буйг заажээ. Өнөөгийн хятадын соёл, боловсрол, шинжлэх ухааны салбар БНХАУ байгуулагдсан үеийнхтэй харьцуулбал харьцангуй түргэн хөгжиж байгаа боловч хөгжилтэй орнуудтай харьцуулахад аанай л хоцрогдсон хэвээр байгаа төдийгүй энэ байдлыг өөрчлөхөд тодорхой цаг хугацаа шаардагдах бөгөөд эдийн засгийн хөгжлийн хурдац, үр ашигт ч зохих муу нөлөө үзүүлж болох тухай дурджээ.

**Байгалийн хүчин зүйлс** болох хүн ам, байгалийн нөөц баялгийн асуудал хятадын хувьд ямар байгааг зохиогч авч үзэхдээ, хэдийгээр социалист нийгмийн байгуулал нь хөдөлмөрийн хүчийг үр ашигтай ашиглах асар их боломж бий болгож, улс орны эдийн засгийг гүнзгийрүүлэн хөгжүүлдэг боловч хятадын хүн ам, ажиллах хүч их байгаа явдал тус улсын нийгэм, эдийн засагт хүндрэл, дарамт учруулж, эдийн засгийн хөгжлийн хурдцыг сулруулахад хүргэж байна гэжээ.

Хятад өргөн уудам нутаг дэвсгэртэй, байгалийн баялаг харьцангуй ихтэй боловч олборлолт, ашиглалт нь хангалтгүй, нэг хүнд ногдох тариалалтын талбай дэлхийн дундаж хэмжээнээс доогуур байгааг мөн онцлон тэмдэглэжээ.

Ийнхүү зохиогч хятадын дотоод нөхцөл байдлын гол онцлогууд, түүнд нөлөөлөх хүчний зүйлсийг тус тусад нь тайлбарлажээ. Зохиогч цаашид «Хятадын онцлогтой социализм байгуулах» тухай ойлголтыг 6 зүйлээр тайлбарлажээ.

1. «Өмчийн бүтэц дахь хятадын онцлог» гэдэг зүйлдээ тэрээр «Ямар ч социалист орон нийгмийн хөгжлийн аливаа нэгэн шатанд үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөхдөө ямар бүтцийг авч хэрэгжүүлэх нь үйлдвэрлэх хүчний хөгжлөөс шалтгаалдаг» тухай өгүүлээд Хятадын үйлдвэрлэх хүчний хөгжлийн түвшин харьцангуй сул дорой байгаа өнөөгийн нөхцөлд гар хөдөлмөр, хагас механикжуулалт, механикжуулалт, автоматжуулалт зэрэг үйлдвэрлэл явуулах төрөл бүрийн арга ажиллагаанууд зэрэгцэн оршиж байгаа нь өмчийн бүтцэд нөлөөлж улс, хоршоолол, хувийн зэрэг өмчийн олон хэлбэрүүд зэрэгцэн хөгжиж болохыг тодорхойлжээ. Түүнээс гадна «нээлттэй хаалга»-ын бодлого болон дотоодод эдийн засгийн шууд харилцаа холбоо өргөжсөний хэрээр гадаадтай хамтарсан, гадаадын худалдаачдын бие даасан аж ахуй зэрэг янз бүрийн хамтарсан аж ахуй болон төрөл бүрийн шилжилтийн шинж чанартай аж ахуйн хэвшлүүд мөн шинээр бий болж байна. Хятадад өмчийн олон хэлбэр ийнхүү хослон хөгжиж байгаа нь тус орны социализмын өвөрмөц нэг зүйл болж байгаа ажээ.

«Эдийн засгийн удирдлагын арга хэлбэр дэх хятадын онцлог» гэсэн хэсэгт зохиогч юуны өмнө, социализм эдийн засгийн төвлөрсөн удирдлагыг зайлшгүй хэрэгжүүлдэг боловч социалист орнуудын төвлөрсөн эдийн засгийн арга хэлбэр тус бүрдээ онцлогтой байдгийг дурьджээ. Хятадын хувьд эдийн засгийн удирдлагын онцлог нь төлөвлөгөөт таваарын эдийн засгийг хэрэгжүүлж, үйлдвэрлэл худалдааг зах зээлээр зохицуулахад орших аж. Төлөвлөгөөт эдийн засаг нь удирдамжийн болон чиглүүлэх шинж чанартай төлөвлөлттэй байх бөгөөд удирдамжийн төлөвлөлтийг хэрэгжүүлэхдээ үнийн хуулийг заавал ашигладаг бол, чиглүүлэх шинж чанартай төлөвлөлт нь эдийн засгийн хөшүүргийг ашиглах

явдалд голчлон түшиглэдэг. Мөн үндэсний эдийн засаг, ард түмний аж амьдралд чухал шаардлагатай бүтээгдэхүүнийг улсаас зохицуулах эдийн засгийн үйл ажиллагааг явуулснаар удирдамжийн төлөвлөлт, хэрэгждэг, бусад ихээхэн хэмжээний бүтээгдэхүүн болон эдийн засгийн чухал үйл ажиллагаанууд нь харилцан адилгүй нөхцөл байдлаас үндэслэн чиглүүлэх шинж чанартай төлөвлөлтийг хэрэгжүүлдэг буюу зах зээлээр зохицуулагдана гэжээ.

«Хуваарилалтын систем дахь хятадын онцлог»-ийн тухайд бичсэн хэсэгтээ зохиогч ХКН-ын ТХ-ны 1978 оны Ш бүгд хурлаас хойш, хийснээр нь хуваарилах зарчмыг хэрэгжүүлж ирсэн нь урьдын «нэг тогооноос хооллох» хуваарилалтын тэгшитгэсэн зарчмаас үндсээрээ ялгаатай болохыг тэмдэглээд хот хөдөөд хуваарилалтын систем өөр өөр хэлбэрээр хэрэгжиж буйг заажээ. Хөдөөд хариуцлагын системийг хэрэгжүүлснээр хийснээр нь хуваарилах зарчим хотынхоос илүү амжилттай хэрэгжиж, харин хотын хувьд энэхүү зарчим аж үйлдвэр, худалдаа болон бусад салбарт өөр өөрийн онцлогт тохирсон тооцооны хэлбэрийг эрж хайх, төвлөрүүлэх, аж ахуйн хариуцлагын төрөл бүрийн хэлбэрийг зөвхөн нэвтрүүлж эхлэх шатанд явж байгааг өгүүлжээ. Зохиогчийн тэмдэглэсэнчлэн, хийснийх нь хэрээр хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх гол хэлбэр болж буй хариуцлагын системийн үндсэн зарчим нь: хариуцлага, эрх, ашиг гурвын харилцаа уялдаа: улс, хоршоолол, хувь хүний эрх ашгийн нэгдэл, албан хаагчдын хөдөлмөрийн орлогыг хөдөлмөрийнх нь үр дүнтэй холбоход оршиж байгаа ба хуваарилалт дахь хятадын онцлог цаашид үргэлжлэх болно гэжээ.

«Засгийн эрхийн хэлбэр дэх хятадын онцлог» хэсэгт зохиогч «Пролетарийн диктатурын ямар хэлбэрийг авч хэрэгжүүлэх нь социалист орон бүрийн онцлогоос шалтгаалах бөгөөд Хятадын хувьд ардын ардчилсан диктатур нь —хятадын онцлогтой пролетарийн диктатур буюу ХКН аас пролетарийн диктатурын тухай марксизмын сургаалыг тус улсын нөхцөл, хувьсгалт уламжлалд нийцүүлэн хийж буй аугаа их өөрчлөлт» (74-р тал) гэж тодорхойлжээ. Улмаар тус улсад шинэ ардчилсан хувьсгал ялсны дараа ардын ардчилсан диктатурт засгийн эрх тогтож, социалист хувьсгал ялснаас хойш ч мөн дээрх хэлбэр байгааг тэмдэглээд ардын ардчилсан диктатурт засгийн эрхийн хэлбэр нь ард түмэн улс орныхоо эзэн гэдгийг тод томруун илтгэн харуулдаг, улс төрийн өндөр ардчиллыг хэрэгжүүлэхэд ашигтай байдгаараа давуу талтай гэж зохиогч дүгнэсэн байна. Энэ утгаараа ч ардын ардчилсан диктатурт засгийн эрхийн хэлбэр нь хятадын одоогийн нөхцөл байдалд болон цаашдын хөгжилд тохирч байгаа аж.

«Оюуны соёлын бүтээн байгуулалт дахь хятадын онцлог» хэмээх хэсэгтээ зохиогч «коммунист үзлийг гол болгосон социалист оюуны соёл нь социализмын чухал шинж чанар, социалист нийгмийн байгууллын давуу тал болдог» гэсэн санааг үндэслэн дээд зэргийн социалист оюуны соёлыг бүтээн байгуулах нь хятадын онцлогтой социализм байгуулах чиг шугамын нэг гэдгийг тэмдэглэжээ. Мөн ХКН-аас дэвшүүлсэн «Өв тэгш, ёс суртахуунтай, соёлтой, сахилга баттай хүмүүжүүлэх» явдал хятадын онцлогтой социалист оюуны соёлын бүтээн байгуулалтын чухал агуулгын нэг болохыг тодорхойлжээ

«Ардчиллын бүтээн байгуулалт дахь Хятадын онцлог» гэсэн эцсийн зүйлд зохиогч хятадын онцлогтой социализмын үндсэн зорилт, зорилгын нэг дээд зэргийн социалист ардчиллыг бий болгоход оршино» (76-р тал) гэж тодорхойлжээ. Ардчиллыг төвлөрүүлэх зарчмын дагуу эдийн

засгийн шинэтгэлийг үргэлжлүүлэн хийж, улс төр, удирдлагын системийг сайжруулж, засгийн эрхэнд ард олныг өргөнөөр оролцуулах замаар социалист байгуулалтад үйлчлүүлнэ гэжээ. Үүний зэрэгцээ Хятадын улс төр, эдийн засаг, соёл, нийгмийн амьдралд ардчиллын хүрээг өргөтгөж, цаашид ардчилал, хуулийн бүтээн байгуулалтыг нэгтгэн хийж, социалист ардчиллын системийг журамлан, хуульчлах болно гэх зэргээр социалист өндөр ардчиллыг бий болгоход ямар ямар зорилт тавьж байгаа талаар дурьдсан нь эл асуудал зорилтоос хэтрээгүйг харуулж байна.

Эцэст нь зохиогч «хятадын онцлогтой социалист байгуулалтын утга учир нь шинжлэх ухааны түгээмэл хуулийг тууштай баримтлан тус орны түүхийн онцлог зүй тогтлыг өөрийн орны байдлаас үүдэн гарсан үндэсний хэлбэр бүхий онцгой туршлагыг бусад нам, ард түмний социалист байгуулалтын явцад олсон нийтийн шинж чанар бүхий туршлагатай үр ашигтайгаар хослуулахад оршино гэж бичжээ.

Зохиогч ийнхүү хятадын онцлогтой социалист байгуулалтын тухай ерөнхий ойлголтыг 6 зүйлээр тайлбарлан бичихдээ, түүний нэг чухал хэсэг гэж тунхаглагдсан «нэг улс, хоёр нийгмийн байгуулал», өөрөөр хэлбэл Хятадыг бусад социалист орнуудын социалист байгуулалтаас онцгой болгож буй «нэг улсад социалист, капиталист хоёр байгуулал зэрэгцэн оршиж болохыг» номлож буй асуудлыг огт хөндөөгүйг тэмдэглэх нь зүйтэй болов уу.